



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ

2021 оны 06 сарын 11 өдөр

Дугаар А/289

Арвайхээр

Хөрөнгө шийдвэрлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.2.1, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2015 оны 04 дүгээр сарын 10-ны өдрийн 25 дугаар тогтоолын "Орон нутгийн өмчит хуулийн этгээд үндсэн хөрөнгө бий болгох, бүртгэх, худалдах, шилжүүлэх" журмын 3.5 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Шүүхийн шийдвэрээр хураагдсан хөрөнгөнд үнэ тогтоох ажлын хэсгийн дүгнэлтийн дагуу үнэ тогтоож худалдах хөрөнгийн худалдах үнийг нэгдүгээр, балансаас балансад шилжүүлэх хөрөнгийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Захирамжийн хоёрдугаар хавсралтад заасан шүүхийн шийдвэрээр хураагдсан Бонго-3 маркийн 41-40 ӨВА улсын дугаартай автомашин, цахилгаан үүсгүүрийг "Өв Агро гурил, тэжээлийн үйлдвэр" ОНӨХХК-д балансаас балансад шилжүүлж, хөрөнгө шилжүүлж авсан байгууллага өөрийн нэр дээр бүртгэхийг гүйцэтгэх захирал (Р.Намгилрагчаа)-д даалгасугай.

3. Хөрөнгө худалдах, шилжүүлэх, бүртгэх, хүлээлгэн өгөх ажлыг зохион байгуулж захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Орон нутгийн өмчийн газар (З.Балданням)-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



А.ИШДОРЖ

011100605

Аймгийн Засаг даргын 2021 оны 06
 дугаар сарын 11-ны өдрийн 11 дугаар
 захирамжийн нэгдүгээр хавсралт



ҮНЭ ТОГТООЖ ХУДАЛДАХ ХӨРӨНГӨ

Д/д	Байгууллага, хөрөнгийн нэр	Марк дугаар	Худалдах үнэ	Тайлбар
1	Шүүхийн шийдвэрээр хураагдсан Даюун маркийн мотоцикль	B396052611	200,000	Сэлбэг хэрэгслээр худалдах
2	Шүүхийн шийдвэрээр хураагдсан Усан помп	3600	200,000	Газар тариалангийн аж ахуй эрхэлдэг хүмүүст худалдах
3	Шүүхийн шийдвэрээр хураагдсан Металь хайгч (таван ширхэг)	- JCHW S/No:52862750865 серийн дугаартай металь хайгч	400,000	Таваг нь гэмтэлтэй, бугуйвч байхгүй- JCHW S/No:52862750865 серийн дугаартай
		- JG3M S/No:53312065558 серийн дугаартай металь хайгч	400,000	Таваг нь гэмтэлтэй, хяналтын самбар хагарсан- JG3M S/No:53312065558 серийн дугаартай
		- MX3J S/No:12599957758 серийн дугаартай металь хайгч	500,000	Таваг нь гэмтэлтэй
		- TMDK S/No:53202054850 серийн дугаартай металь хайгч	500,000	
		- TMDK S/No:634910552 серийн дугаартай металь хайгч	500,000	
4	Шүүхийн шийдвэрээр хураагдсан Жижиг оврын гар аргаар хийсэн Файжуур			7-8 кг жинтэй төмөр, төмрийн хаягдалд өгөх

06 Аймгийн Засаг даргын 2021 оны
дүгээр сарын 11-ны өдрийн 11 дугаар
захирамжийн хоёрдугаар хавсралт



БАЛАНСААС БАЛАНСАД ШИЛЖҮҮЛЭХ ХӨРӨНГӨ

Д/д	Байгууллага, хөрөнгийн нэр	Улсын дугаар	Үйлдвэрлэсэн он	Ашиглалтад орсон он	Бүртгэлд тусгах		Бүртгэх байгууллага
					үнэ	Цаашид ашиглах жил	
1	Шүүхийн шийдвэрээр хураагдсан Бонго-3 маркийн автомашин	41-40 ӨВА	2007	2019	10,000,000	8 жил	"Өв Агро гурил, тэжээлийн үйлдвэр"
2	Шүүхийн шийдвэрээр хураагдсан Цахилгаан үүсгүүрийн мотор	-	-	-	500,000	5 жил	"Өв Агро гурил, тэжээлийн үйлдвэр"

-oOo-